

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

(1996 оны үйл явдлын тойм)

— ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төв «Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа ба Монгол Улс», «Монголын түүхийн зарим асуудал ба Монгол Хятадын түүхэн харилцаа» хэмээх хоёр төслийн судалгааг гүйцэтгэж эхлэв,

— Шинжлэх ухаан нийгэм-улс төрийн «Зүүн хойт Ази судлал» сэтгүүлийн 1996 оны № 1 (7), (3,5 хх)-ийг нийтлэн гаргаж уншигчдын хүртээл болгов. Сэтгүүлийн энэхүү дугаарыг Япон улс судлалд зориулан бэлтгэсэн юм.

— Академич Ч. Далайн туурвисан Монгол улсын түүхийн цуврал бүтээлийн тэргүүн боть «Хамаг Монгол Улс (1101-1206)» (УБ, 1996, 10 хх) хэвлэгдэн нийтийн хүртээл болов,

— Тус төвөөс эрхлэн нэгдүгээр сарын 30нд Токиогийн Гадаад хэлний их сургуулийн Ази, Африкийн хэл соёлын хүрээлэнгийн монголч эрдэмтэн, профессор Наками Тацуо-тай Уулзалт ярилцлага зохиов, Уулзалтын үед Монгол судлал, Зүүн хойт Ази судлалын өнөөгийн тулгамдсан асуудлаар санал солилцлоо,

— Зургадугаар сарын 24-нд Төвийн захирал, академич Ч. Далай төвийн Урилгаар хүрэлцэн ирсэн АНУ-ын Иллинойсын их сургуулийн Зүүн Ази, Номхон далай судлалын төвийн захирал, профессор Т. Ю. Жорж-той уулзан хэлэлцээр хийж «Монгол улсын ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төв, АНУ-ын Иллинойсын их сургуулийн Зүүн Ази, Номхон далай судлалын төвийн хооронд хамтын ажиллагааны тухай гэрээ»-нд гарын үсэг зурав,

— Зүүн хойт Ази судлалын төвөөс Монголын тулгар төр байгуулагдсаны 790 жил, Ардын хувьсгалын 75 жилийн ойг угтаж гадаад, дотоодын эрдэмтдийг оролцуулан дугуй ширээний цуврал ярилцлагыг зохион байгуулав, Үүнд;

— Зургадугаар сарын 21нд эрдэм шинжилгээний ээлжит ярилцлагыг зохион байгуулж, академич Ч. Далай «Япон дахь Их Монгол улсын судалгаа», Японы Осакагийн олон улсын харилцааны их сургуулийн профессор монголч эрдэмтэн Мацуда Коичи «Өгээдэй хааны үеийн цэргийн хүчин чадал» гэсэн илтгэл тавьж, илтгэлтэй холбогдуулан түүхийн ухааны доктор Ц. Ишдорж, С. Дамдинсүрэн, А. Очир нарын зэрэг эрдэмтэд үг хэлж, санал бодлоо солилцов,

— Зургадугаар сарын 26-нд их ойг угтсан цуврал уулзалтын хүрээнд тус төвөөс БНХАУ-ын ӨМИС-ийн хөрш орнуудын судалгааны институттай хамтран дугуй ширээний ярилцлага зохион байгуулав, Ярилцлагад Зүүн хойт Ази судлалын төвийн хамт олон, БНХАУ-ын ӨМИС-ийн Хөрш орнуудын судалгааны хүрээлэнгийн захирал Энхээ, мөн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Улаан-Од, Цэрэнхүү нар оролцлоо, Мөн Осакагийн Олон Улсын харилцааны их сургуулийн профессор К. Мацуда оролцлоо,

Наймдугаар сарын 26—29-нд Чанчунь хотноо Хятадын Жилин мужийн Нийгмийн ШУА, Жилин мужийн ЗХА судлалын төвөөс зохиосон «ЗХА-ийн энх тайван, аюулгүй байдал, хөгжил» сэдэвт олон улсын хуралд академич Ч. Далай, эрдэм шинжилгээний ажилтан Л, Бэгзжав нар оролцож, Ч. Далай «Монгол дахь ЗХА судлалын зарим асуудал», Л. Бэгзжав «Монголын дорнод хэсэг түмэн голын хөтөлбөрт холбогдох нь» гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв:

—Тус Төвийн урилгаар АНУ-ын Иллинойсын их сургуулийн Зүүн Ази, Номхон далай судлалын төвийн захирал, профессор Жорж Т, Ю, Япон улсын Осакагийн олон улсын харилцааны их сургуулийн профессор, монголч эрдэмтэн К, Мацуда, БНХАУ-ын ӨМИС-ийн Хөрш орнуудыг судлах хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Улаан-Од, Түмэнцэцэг нар хүрэлцэн ирж ажиллав,

— Хоёр байгууллагын хамтын ажиллагааны шугамаар тус төвийн төлөөлөгчид (Л Хайсандай, Б, Сэржав нар) 10-р сарын 13—21-нд БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн хөрш орон судлалын хүрээлэнд албан томилолтоор ажиллав, Тэнд ажиллах хугацаандаа тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний болон Монгол улстай ажил төрлийн хэлхээ холбоотой ажилладаг байгууллага пазрын ажилтнуудад «Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа ба Монгол Улс», «1996 оны УИХ-ын сонгуулийн дараах Монгол Улсын нийгэм эдийн засаг, улс төрийн байдал», «90-ээд оны Монгол, Японы харилцаа» сэдвүүдээр илтгэл хийж чөлөөт ярилцлага зохиожээ, Төлөөлөгчдийг ӨМӨЗО-ны Улсын их сургуулийн дэд ректор, доктор, профессор Хөгжилт, Хөрш орон судлалын хүрээлэнгийн захирал, Энхээ, орлогч захирал Баатар нар хүлээн авч уулзан хоёр байгууллагын хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.